



**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**

**АЙМГУУДЫН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН
2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ТОВЧ
ТАНИЛЦУУЛГА**

**УЛААНБААТАР ХОТ
2019 ОН**

АЙМГУУДЫН ХҮНС, ХӨДӨӨ, АЖ АХУЙН ГАЗРЫН 2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2019.02.21

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

1.1. Аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газраас хэрэгжүүлсэн үйл ажиллагааны гүйцэтгэлийн хүрсэн түвшинг тогтоож, удирдлагыг бодит мэдээлэл, санал-дүгнэлт, зөвлөмжөөр хангах, мөн түүнчлэн байгууллагын гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хариуцлагыг сайжруулах зорилготой.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилт

2.1. Хүнс, хөдөө аж ахуйн салбарын бодлогын зорилт нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэхэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг тооцно.

2.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн, дүгнэлтийг үндэслэн салбарын байгууллагууд үйл ажиллагааны зорилтоо тодорхойлох төлөвлөгөө, бодлогын хувилбар, санал боловсруулахад дэмжлэг үзүүлэх, агентлагийн дарга, Засаг дарга болон холбогдох байгууллагын удирдлагад шийдвэр гаргахад бодлогын дэмжлэг үзүүлнэ.

2.3. Хүнс, хөдөө аж ахуйн салбарын байгууллагын стратеги зорилт, үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, төлөвлөлт, гүйцэтгэл, дунд болон урт хугацааны үр дүн, үр нөлөөг сайжруулна.

2.4. Байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн санг бүрдүүлж, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээр хангана.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

3.1 Аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газрын үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2017 оны А/159 дүгээр тушаалаар батлагдсан “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”-ыг удирдлага болгов.

3.2 Ерөнхий үнэлгээний дүнг гаргахдаа бүрэлдэхүүн хэсгүүдийг ач холбогдлоор нь эрэмбэлэн, нийт дүнд (100) эзлэх итгэлцүүр тогтоосон бөгөөд энэ нь бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнд 20 хувь, байгууллагын чиг үүргийн үзүүлэлтэд 20 хувь, байгууллагын нээлттэй байдлын үнэлгээнд 10 хувь, үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээнд 50 хувь байхаар тус тус тооцов. Бүрэлдэхүүн тус бүрийн үнэлгээг гаргахдаа /дэд хэсгийн/ биелэлтийн дундаж хувиар тооцсон болно.

3.3 Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ аймгуудын үйл ажиллагааны болон хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг судлах, 2017, 2018 оны статистик дүн, яамны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрууд болон харьяа байгууллагуудад аймгуудаас ирүүлсэн

мэдээ, мэдээлэлтэй харьцуулалт хийх болон хариуцсан мэргэжилтнээс тодруулга авч нягтлах зэрэг үндсэн аргуудыг ашиглав.

Мөн тайлангийн чанар, агуулга, мэдээллийн үнэн бодит байдал, заасан хугацааг баримталсан эсэхийг үнэлгээний дүнд харгалзан үзсэн болно.

Дөрөв. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2018 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ 4 бүрэлдэхүүн хэсэг, 12 дэд хэсгийг хамарсан бөгөөд ерөнхий үнэлгээ дунджаар 86.0 хувьтай гарч байна /Нэгдүгээр хүснэгт/.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТОВЧОО

Хүснэгт-1

Үзүүлэлт		Хяналт-шинжилгээ, үнэлгээ, хувь
Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ	Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	89.6
	Үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх хүрээнд аймгийн ЗД, ИТХ-аас баталсан дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилт; /ХХАА-н салбарт хэрэгжиж буй 5 дэд хөтөлбөр/	84.6
	Аймгийн эдийн засаг, нийгмийг тухайн онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт;	91.5
	ДУНДАЖ	88.6
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	Төсвийн ерөнхийлөн захирагчаас ХХААГ-ын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт;	83.6
	Сумдын мал эмнэлэг, үржлийн тасгийн тухайн жилийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн үнэлгээ	83.1
	Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний биелэлт;	85.8
	ДУНДАЖ	84.2
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын тайлан	93.4
	Хэрэглэгчийн үнэлгээ	73.3
	ДУНДАЖ	83.4
Үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ	Хүнсний салбар	86.5
	Мал эмнэлгийн салбар	85.2
	Мал аж ахуйн салбар	89.0
	Газар тариалангийн салбар	86.6
	Хөнгөн, ЖДҮ	83.6
	ДУНДАЖ	86.2
ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ		86.0

АЙМГУУДЫН ХХААГ-ЫН 2018 ОНЫ АЖЛЫН ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭ

2/21/2019

№	Аймгууд	Үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ /50 оноо/					Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ /20 оноо/					Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ /20 оноо/					Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ /10 оноо/					Үнэлгээний оноо	Эзэлсэн байр	
		Хүнс	Мал эмнэлэг	Мал аж ахуй	Газар тариалан	Хөнгөн, ЖДҮ	Үнэлгээ		Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр	Дэд хөтөлбөрүүдийн үнэлгээ	Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл	Үнэлгээ		Сайд, ХХААГ-ын даргатай байгуулсан гэрээний биелэлт	ХХААГ, сумын МЭҮТ-гай байгуулсан гэрээний биелэлт	Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний биелэлт	Үнэлгээ		Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын тайлан	Хэрэглэгчийн үнэлгээ	Үнэлгээ			
							ХШҮ, хувь	ОНОО				хувь	ОНОО				ХШҮ, хувь	ОНОО			ХШҮ, хувь			ОНОО
1	Архангай	82.4	76.1	87.9	75.6	84.8	81.3	40.7	94.0	85.0	70.0	83.0	16.6	85.4	80.7	82.5	82.9	16.6	97.5	70.0	83.8	8.4	82.22	
2	Баян-Өлгий	78.4	85.0	88.1	76.7	89.5	83.5	41.8	86.7	91.8	95.0	91.2	18.2	85.2	73.5	81.8	80.2	16.0	93.0	70.0	81.5	8.1	84.18	
3	Баянхонгор	80.2	91.1	89.6	85.9	80.3	85.4	42.7	90.0	75.0	90.6	85.2	17.0	79.7	85.6	91.9	85.7	17.1	99.5	70.0	84.8	8.5	85.37	
4	Булган	94.3	81.2	89.1	88.1	85.9	87.7	43.9	93.0	92.6	98.4	94.7	18.9	85.7	89.8	84.6	86.7	17.3	98.5	70.0	84.3	8.4	88.56	VI
5	Говь-Алтай	82.7	83.0	88.7	82.8	85.4	84.5	42.3	88.5	63.5	92.1	81.3	16.3	85.7	89.2	76.2	83.7	16.7	100.0	70.0	85.0	8.5	83.76	
6	Дорноговь	83.0	85.5	90.7	86.9	81.9	85.6	42.8	97.0	90.0	97.2	94.7	18.9	86.0	62.4	75.1	74.5	14.9	85.0	70.0	77.5	7.8	84.40	
7	Дорнод	88.4	80.8	90.5	86.0	82.0	85.5	42.8	84.3	92.5	95.0	90.6	18.1	81.5	79.2	89.5	83.4	16.7	99.0	70.0	84.5	8.5	86.01	X
8	Дундговь	80.6	76.4	87.8	75.5	81.0	80.3	40.1	88.5	85.8	89.3	87.9	17.6	67.2	85.4	85.0	79.2	15.8	98.8	70.0	84.4	8.4	81.98	
9	Завхан	81.7	90.3	84.6	87.6	78.5	84.5	42.3	84.5	90.0	90.0	88.2	17.6	84.1	80.6	84.6	83.1	16.6	100.0	70.0	85.0	8.5	85.03	
10	Өвөрхангай	93.6	82.8	88.7	92.9	94.7	90.5	45.3	95.9	74.3	96.6	88.9	17.8	87.9	82.4	85.8	85.4	17.1	93.5	100.0	96.8	9.7	89.81	IV
11	Өмнөговь	79.7	82.2	88.4	92.8	83.1	85.2	42.6	91.1	91.0	89.2	90.4	18.1	84.7	89.9	84.8	86.4	17.3	95.0	70.0	82.5	8.3	86.24	IX
12	Сүхбаатар	85.8	90.9	87.8	81.1	85.7	86.2	43.1	86.1	85.4	85.0	85.5	17.1	85.0	80.2	83.2	82.8	16.6	100.0	70.0	85.0	8.5	85.28	
13	Сэлэнгэ	88.9	82.3	92.0	94.1	79.1	87.3	43.6	92.6	78.6	93.1	88.1	17.6	86.9	68.5	89.5	81.6	16.3	97.5	70.0	83.8	8.4	85.96	
14	Төв	97.6	87.9	88.5	93.7	86.7	90.9	45.4	81.2	90.7	96.1	89.3	17.9	84.8	89.4	92.5	88.9	17.8	97.5	90.0	93.8	9.4	90.46	I
15	Увс	86.4	82.6	87.8	92.8	81.4	86.2	43.1	95.0	85.3	88.0	89.4	17.9	86.6	90.8	91.4	89.6	17.9	98.3	70.0	84.1	8.4	87.32	VII
16	Ховд	76.2	88.9	88.5	91.0	81.5	85.2	42.6	74.4	78.2	77.0	76.5	15.3	81.5	82.4	82.5	82.1	16.4	85.0	70.0	77.5	7.8	82.09	
17	Хөвсгөл	92.5	91.6	94.4	82.3	81.9	88.5	44.3	91.5	91.2	95.7	92.8	18.6	84.2	88.5	94.4	89.0	17.8	94.7	70.0	82.4	8.2	88.87	V
18	Хэнтий	90.7	90.7	92.3	92.2	85.3	90.2	45.1	92.2	84.5	100.0	92.2	18.4	83.0	87.0	86.1	85.4	17.1	50.0	70.0	60.0	6.0	86.63	VIII
19	Дархан-Уул	100.0	82.1	91.4	88.7	91.9	90.8	45.4	98.8	85.0	100.0	94.6	18.9	86.3	90.0	85.0	87.1	17.4	91.5	80.0	85.8	8.6	90.32	II
20	Орхон	93.5	93.3	85.5	94.0	80.8	89.4	44.7	92.0	94.0	95.5	93.8	18.8	85.1	91.9	91.4	89.5	17.9	90.0	80.0	85.0	8.5	89.87	III
21	Говьсүмбэр	80.8	85.2	86.7	77.3	74.6	80.9	40.5	84.2	72.5	87.6	81.4	16.3	78.9	78.0	85.0	80.6	16.1	97.5	70.0	83.8	8.4	81.24	
	Дундаж	86.5	85.2	89.0	86.6	83.6	86.2	43.1	89.6	84.6	91.5	88.6	17.7	83.6	83.1	85.8	84.2	16.8	93.4	73.3	83.4	8.3	85.98	

4.1. Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ

Уг бүрэлдэхүүн хэсэг нь Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, Үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх хүрээнд аймгийн ЗД, ИТХ-аас баталсан дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилт, Аймгийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт гэсэн дэд хэсэгтэй ба эдгээр бодлогын баримт бичигт тусгагдсан салбарт хамаарах арга хэмжээний хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс тухайн зорилт, арга хэмжээг үнэлсэн дүнгээр авсан. “Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ” бүрэлдэхүүн хэсгийн дундаж үнэлгээ **88.6** хувьтай байна.

График-1



Хэд хэдэн аймгууд бодлогын зорилтын үнэлгээний дүнг хугацаа хоцруулж ирүүлсэн, мөн аймгийн ХШҮДАХ-ээр дүгнүүлээгүй зэрэг тайлагналтын алдаа гарсныг залруулах, энэ нь эргээд үнэлгээнд сөргөөр нөлөөлөх, үнэлгээг ялгавартай гаргах, бага үнэлэгдэх зэрэг нөхцөлийг бүрдүүлж байна. Цаашид тухайн тайлант жилийн дүнг аймгийн Засаг даргын тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтсээр баталгаажуулж ирүүлэх шаардлагатай.

4.1.1. Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

Хүнс, хөдөө аж ахуйн газрууд Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан хүнс, хөдөө аж ахуйн салбарт хамаарах арга хэмжээг хяналтад авч хэрэгжүүлж дүнг аймгийн ЗДТГ-ын ХШҮДАХ-ээр дүгнүүлж 74.4-97.0 хувиар дүгнэгдэн ирүүлсэн байна. Дэд хэсгийн хэрэгжилт ба дундаж үнэлгээ **89.6** хувьтай дүгнэгдсэн байна. /График-2/

График- 2



4.1.2. Үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх хүрээнд аймгийн ЗД, ИТХ-аас баталсан дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилт

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хэрэгжиж буй “Монгол мал”, “Сав баглаа боодол”, “Мах, сүүний анхдугаар аян”, “Төрөөс Хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”, “Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр” зэрэг дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилт дунджаар **84.6** хувь гэж дүгнэгдсэн /График-3/. Дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн үнэлгээгээр Дорнод, Орхон аймгууд харьцангуй өндөр дүгнэгдсэн бол Говь-Алтай, Говьсүмбэр аймгууд хамгийн бага үнэлгээтэй байна.

График- 3



4.1.3. Аймгийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт

Аймгууд тухайн аймгийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төлөвлөгөөнд хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамаарах арга хэмжээг тус бүр хяналтад авч хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан байна. Дэд хэсгийн хэрэгжилт 70.0-100.0 хувьтай дүгнэгдсэн ба дундаж үнэлгээ **91.5** хувьтай байна. /График-4/ 90 хувь хүртэл үнэлгээтэй 7 аймаг, бусад аймаг нь 90 хувиас дээш үнэлгээтэй хэрэгжсэн дүнтэй байна.

Аймгуудын үндсэн чиглэлд тусгагдсан ХХААХҮ-ийн салбарт хамаарах арга хэмжээний тоо хэт өндөр зөрүүтэй байгаа нь төлөвлөлтийг үндэслэлтэй, судалгаанд тулгуурлан бодитой хийх шаардлага байгааг харуулж байна. Үндсэн чиглэл нь богино хугацааны бодлогын баримт бичиг бөгөөд нэг жилийн хугацаанд хэрэгждэг тул хэрэгжих боломжтой, тодорхой үр дүнд хүрэх, санхүүжилт шийдвэрлэгдсэн арга хэмжээнүүдийг оруулах нь зүйтэй юм.

График -4




4.2. Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ

Уг бүрэлдэхүүн хэсэг нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдаас ХХААГ-ын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт, Аймгийн ХХААГ-аас Сумдын мал эмнэлэг, үржлийн тасагтай байгуулсан тухайн жилийн хамтран ажиллах гэрээний биелэлтийн дүн, Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний биелэлт гэсэн дэд хэсгүүдтэй ба “Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ” бүрэлдэхүүн хэсгийн дундаж үнэлгээ **84.2** хувьтай дүгнэгдлээ.

4.2.1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдаас ХХААГ-ын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдаас ХХААГ-ын даргатай байгуулсан 2018 оны үр дүнгийн гэрээний биелэлтэд аргачлалын дагуу яамны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрууд үнэлгээ хийж, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлсэн. Гэрээний үр дүнгийн дундаж үнэлгээ **83.6** хувьтай байна.


График- 5



4.2.2. Аймгийн ХХААГ-аас Сумдын мал эмнэлэг, үржлийн тасагтай байгуулсан тухайн жилийн хамтран ажиллах гэрээний биелэлтийн дүн

Аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газруудаас сумдын мал эмнэлэг, үржлийн тасагтай байгуулсан 2018 онд хамтран ажиллах гэрээг дүгнэсэн дүн дунджаар **83.1** хувьтай, үүнээс хамгийн өндөр үнэлгээтэй нь Увс, Орхон, Дархан-Уул, Өмнөговь аймгууд байна.

График- 6




4.2.3. Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний биелэлт

Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний биелэлтийг үнэлэхдээ байгууллагын үйл ажиллагаанд Үндэсний болон аймгийн аудитын газраас хийсэн санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитын зөвлөмж болон ХХААХҮЯ-аас хөтөлбөр, төслийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг харгалзан дүгнэлээ.

Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний хэрэгжилт дунджаар 85.8 хувьтай үнэлэгдсэн ба Хөвсгөл, Төв, Баянхонгор аймгууд харьцангуй сайн дүгнэгдэж бусад аймгуудаа тэргүүлсэн.


График -7



4.3. Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ

Уг бүрэлдэхүүн хэсгийн Хэрэглэгчийн үнэлгээ дэд хэсэг болон ил тод байдлын тайланд яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар үнэлгээ хийв. “Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ” бүрэлдэхүүн хэсгийн дундаж үнэлгээ **83.4** хувьтай байна.

График -8




4.3.1. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын тайлан

Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолоор батлагдсан “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”-ийн биелэлт дунджаар **93.4** хувьтай үнэлэгдсэн. Аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газрын цахим хуудасны ашиглалт, мэдээлэл түгээлт харилцан адилгүй байна.

Хүнс, хөдөө аж ахуйн газрууд байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарынхаа бүтэц, агуулгыг сайжруулан, цаг үеийн мэдээллээ тогтмол оруулж, төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр хэрэглэгчдэд хүргэх, талаар санаачлагатай ажиллан үйл ажиллагааны ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтийн тайландаа тусгахад анхаарах хэрэгтэй.

Мөн ил тод байдлын тайланг ирүүлэхдээ үр дүнгээ тооцоолж тайлагнаагүй нийтлэг алдаа дутагдал байна. Тухайлбал төлөвлөгөө болон биелэлт тодорхой бус, хүрсэн үр дүнг тооцоололгүй тайлагнасан нь дүгнэлтэд сөргөөр нөлөөлж байгаа тул, цаашид төлөвлөх болон тайлагнах шатанд анхаарах шаардлагатай байна.


График-9



4.3.2. Хэрэглэгчийн үнэлгээ

Аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газрын үйл ажиллагаанд өгсөн хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаанд хамрагдсан иргэдийн дундаж үнэлгээ 73.3 хувьтай байна.

График-10



Хэрэглэгчийн үнэлгээг хийлгэхдээ Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2017 оны 302 дугаар тушаалаар баталсан “Хэрэглэгчийн үнэлгээний ерөнхий удирдамж”-ийг мөрдлөг болгон хийлгэх шаардлагатай байна. 2018 оны хэрэглэгчийн үнэлгээг хангалтгүй ирүүлсэн аймаг олон байна. Хэрэглэгчийн үнэлгээг хийлгэхдээ судалгааны зорилго болон түүнд тохирсон асуултыг урьдчилан бэлтгэж, судалгаанаас ямар мэдээлэл дүн шижилгээ авах хэрэгтэй байгааг сайтар ойлгож байж хийж гүйцэтгэх хэрэгтэй байна. Мөн судалгааг ижил

төрлийн зөвлөх үйлчилгээ хийлгэж байсан туршлагатай байгууллагаар гүйцэтгүүлэхэд анхаарах шаардлагатай.

4.4. Үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ

Аргачлалд тусгагдсанаар уг бүрэлдэхүүн хэсэг нь хүнс, мал эмнэлэг, мал аж ахуй, газар тариалан, хөнгөн үйлдвэр, хоршоо, жижиг дунд үйлдвэрийн салбар гэсэн дэд хэсгүүдтэй ба “Үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ” бүрэлдэхүүн хэсгийн дундаж үнэлгээ **86.2** хувьтай байна.

График-11



4.4.1. Хүнсний салбар

ХХААХҮ-ийн сайдын 2017 оны А-159 дүгээр тушаал, “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу хүнс үйлдвэрлэлийн салбарын үр дүнгийн үзүүлэлтийг дор дурдсан таван багц асуудлаар үнэлдэг. Үүнд:

- Орон нутгаас хүнсний салбарт үзүүлсэн дэмжлэг
- Хүнсний үйлдвэрийн тоо, тэдгээрийн хүчин чадлын ашиглалт
- Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл
- Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний орон нутгийн үйлдвэрлэлээр хангах хувь
- Хүнсний аюулгүй байдлын чиглэлээр хийсэн ажил

Орон нутгаас хүнсний салбарт үзүүлсэн дэмжлэгийн талаар: Өнгөрсөн онд 21 аймаг хүнсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр орон нутгаас нийт 1 837,2 сая төгрөг хуваарилж, хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч 680 аж ахуй нэгж, иргэнд 7 171,3 сая төгрөгийн зээл олгосон мэдээтэй байна. Тус салбарт хүнс үйлдвэрлэлийн 102 цех, 29 үйлдвэр шинээр ашиглалтад орсон.

Орон нутгийн хөрөнгө оруулалт, хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлснээр дотоодын хүнсний хангамжийн нэмэгдсэн байдал, зээл ашиглалт, түүний үр өгөөжийн талаарх мэдээлэл дутуу, үнэн бодитой эсэх нь эргэлзээтэй байсан тул нэгдсэн тоо баримт гаргах, дүгнэлт хийх, бодлогын зөвлөмж өгөх боломж бүрдүүлсэнгүй.

Хүнсний үйлдвэрийн тоо, тэдгээрийн хүчин чадлын ашиглалтын талаар:

ХХААГ-ын ирүүлсэн мэдээгээр 1770 хүнсний үйлдвэр, 1125 цех, 5083 хүнсний дэлгүүр үйл ажиллагаа явуулж байгаа гэсэн нь статистикийн тооноос зөрүүтэй байгаа нь зарим аймаг холбогдох мэдээ баримт ирүүлээгүйтэй холбоотой.

Хүснэгт-3

	Тоо	Ашиглалтын хувь, %	Тайлбар
Хүнсний үйлдвэр	1770	64,9	5 аймаг тоо ирүүлээгүй
Хүнсний цех	1125	79,1	4 аймаг тоо ирүүлээгүй
Хүнсний дэлгүүр	5083	-	7 аймаг тоо ирүүлээгүй

Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн талаар: Орон нутагт 28 мянган тн. мах, махан бүтээгдэхүүн, 43.3 мянган тн. сүү сүүн бүтээгдэхүүн үйлдвэрийн аргаар боловсруулсан байна.

Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний орон нутгийн үйлдвэрлэлээр хангах

хувь: Орон нутгаас мах, сүү, гурил, төмс, хүнсний ногооны хэмжээний үзүүлэлтээр мах, махан бүтээгдэхүүн 88.6, сүү, сүүн бүтээгдэхүүн 74.8, гурил 64.3, төмс 63, хүнсний ногоо 31.5 хувиар хангаж байгаа дундаж үзүүлэлттэй гарсан. Үйлдвэрийн аргаар боловсруулсан махны хэмжээ 18.1; сүүний хэмжээ 16.7 хувьтай гарсан нь улсын дунджаас өндөр, бодитой бус үзүүлэлт бөгөөд хүнсний үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтнүүдийн ажилдаа хандах хариуцлагын илрэл гэж дүгнэх үндэстэй.

Хүнсний аюулгүй байдлын чиглэлээр хийсэн ажил:

- Нийт 252 удаагийн сургалтад 535 хоног, 500.5 сая төгрөг зарцуулан 29,600 хүн хамруулсан дүнтэй байна.
- Хүнс хэрэглэгчийн боловсролд зориулан 67.0 сая төгрөг зарцуулан 1502 удаагийн үйл ажиллагаа явуулжээ.
- Нийт 123 удаагийн үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, 68,602 аж ахуйн нэгж, иргэн оролцуулж, 5.6 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн.
- Мэргэжлийн хяналтын байгууллагаас хийсэн 89 удаагийн хяналт шалгалтад оролцоо хангасан байна.

Тайлагналттай холбоотой анхаарал асуудал:

- Дархан-Уулаас бусад аймаг 2017 оны үйл ажиллагааны тайланд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнд өгсөн хүнсний үйлдвэрлэлийн зөвлөмжийн биелэлттэй танилцаагүй, биелүүлээгүй, тайлагнаагүй ноцтой зөрчил гаргасан.
- Үр дүнг бус үйл ажиллагааг тоочих байдлаар тайлагнахгүй гэсэн заалт байнга зөрчигдөж байна.
- Бусад байгууллагатай хамтарч хийсэн ажлыг ялгаа заагийг нарийн ялгаж бичихгүй тайлагнах асуудал түгээмэл байна.


Дүгнэлт:

- Хөрөнгө оруулалт, зээлийн дэмжлэг нэмэгдсэн боловч нутгийн хүнсний хангамж, үйлдвэрлэлийн өсөлт, эдийн засгийн хөгжил, үр дүн, үр нөлөө тайлаас нь тайлагнах шаардлагатай.

- Хяналт-шинжилгээ, үнэлгээг тайлан дээр суурилан хийж, нэмэлт материал, тайлбар, ярилцлагын үндсэн дээр баталгаажуулж авдаг. Тайлангийн үнэн бодитой байдлыг дээд шатны байгууллага бүрэн нотлох хүний болон цаг хугацаа, хөрөнгийн нөөц хомс бөгөөд харилцан итгэлцэл дээр тулгуурлан үйл ажиллагааны үнэлэлт өгч байгаа. Гэтэл зарим мэргэжилтнүүдийн ажилдаа хандах хандлага, хариуцлага хангалтгүй, салбарын хөгжлийн төлөө чин сэтгэлээсээ ажиллах бус тухайн үед аргалаад өнгөрөх аргацаасан сэтгэхүйгээр ажиллаж байгаа нь харамсалтай.

- Холбогдох журам, аргачлалд заасан үнэн бодитой, зөв тайлагнах асуудлыг зөрчиж байна. Ирүүлсэн зарим үзүүлэлтийн үр дүн ирүүлэхгүй байх, нэгж зөрүүлэх, өмнөх жилийн болон оны эхэнд ирүүлсэн суурь түвшингээс зөрүүтэй байх, суурь түвшинг зориуд бууруулж засах, тайлангаас нь асуухад тайлбарлаж мэдэхгүй байх зэрэг ноцтой зөрчлүүд илэрсээр байна.

График-12



Зөвлөмж болгох нь:

4.4.2. Мал эмнэлгийн салбар

Мал эмнэлгийн салбарын 2018 оны үйл ажиллагааны хэрэгжилтийг үнэлэхдээ “Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ”, “Бруцеллэз өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ”, “Паразит өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээ”, “Ариутгал халдваргүйтгэл”, “Лабораторийн шинжилгээ”, “Мэдээ тайланд өгсөн Мал эмнэлэг, үржлийн газрын үнэлгээ”, “Тайлангийн агуулга, чанарт өгсөн үнэлгээ” зэрэг бүрэлдэхүүн хэсгүүдийн хүрээнд 13 шалгуур үзүүлэлтийг харгалзан хийлээ. Дэд хэсгийн хэрэгжилтийн үнэлгээ дунджаар **84.2** хувийн дүнтэй үнэлэгдсэн.


Салбарын хувьд.

1. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль хэрэгжиж эхэлсэн хэдий ч салбарын үйл ажиллагаанд мөрдөх баримт бичгүүд батлагдаагүй, бүтэц, бүрэлдэхүүний томилгоо бүрэн хийгдээгүй байгаагаас үйл ажиллагаа жигдрээгүй байна,

2. Мал эмнэлгийн байгууллагууд нь түвшин түвшиндээ мэргэжилтнүүдийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, чадамжийг нэмэгдүүлэх шаардлагатай,
3. МЭЕГ-аас захиалгаар гүйцэтгүүлсэн гэрээт ажлын тайланг тухайн ондоо багтаан дүгнээгүй, тайланг хүлээн аваагүй асуудал байгааг цаашид залруулах шаардлагатай,
4. Урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын арга хэмжээнд хяналтыг хэрэгжүүлсэн талаарх тайлагналт хангалтгүй,
5. Мал эмнэлгийн үйлчилгээний жишиг норм, норматив тогтоох зөвлөх үйлчилгээний тендерийн санал, тооцоолол дээр тулгуурлан мал эмнэлгийн үйлчилгээний санхүүжилтийн нормативыг яаралтай баталж мөрдөх, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн санхүүжилтийн найдвартай механизм бий болгох замаар мал эмнэлгийн үйлчилгээний хүртэмжийг сайжруулах,
6. Шинээр бий болсон мал эмнэлгийн салбарын бүтцийн хүрээнд тархвар зүйчдийг сургах, чадавхжуулах ажлыг нэн яаралтай хэрэгжүүлэх,
7. Халдваргүй өвчний мэдээ ирүүлснээс үзэхэд 2017 онтой харьцуулахад 2018 оны гаралт 41.5 хувиар өссөн байна. Халдваргүй өвчний мэдээллийн маягтыг эрхтэн тогтолцоогоор бус өвчний нэрээр гаргаж, халдваргүй өвчинтэй тэмцэх арга хэмжээнд шинжлэх ухаанчаар хандах шаардлагатай. Тухайлбал халдваргүй хордлогот өвчнүүдийн асуудлыг чухалчлан авч үзэх шаардлагатай байна.
8. Шимэгчтэх өвчний нэг хэсэг нь халдварт өвчний мэдээнд бүртгэгдсээр байгаа тул мэдээний маягтыг цэгцэлж, мэдээг зөв ирүүлж хэвшүүлэх, Нийлүүлгийн өвчин, Бабеиоз, Адууны хачгийн халуун гэх мэт

Аргачлалд заасан шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

1. **Аргачлалд заасан шалгуурын үнэлгээ 84.2 хувь буюу 4.21 оноотой дүгнэгдсэн бол үр дүнгийн гэрээний үнэлгээ 81.6 хувь буюу В үнэлгээтэй дүгнэгдлээ,**
2. Үр дүнгийн гэрээ байгуулахдаа ТЗУГ-аар хянуулж, баталгаажуулах. Хамааралгүй зорилт, арга хэмжээ тусган гэрээ байгуулсан асуудал байна,
3. Арга хэмжээ тус бүрээр бус зөвхөн зорилтот түвшингээр шалгуур тогтоосон нь үнэлгээ хийхэд хүндрэл бий болгож байна,
4. Үр дүнгийн гэрээнд тусгасан тоон мэдээллүүд нь жилийн эцсийн бусад тайланд багтсан тоон мэдээллээс зөрүүтэй, нотлох баримтаар баяжигдаагүй,
5. Төлөвлөлтийн тухай тайлагнах заалтад гүйцэтгэл тайлагнасан,
6. Өөрчлөлт гаргах шалгуурт хэрхэн өөрчлөлт гарсныг тайлагнаагүй.
7. Урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний талаар тайлагнах заалтуудад зөвхөн вакцинжуулалтын талаар тайлагнаж байна. Өвчнөөс урьдчилан сэргийлэх бусад арга хэмжээ, тэмцэх арга хэмжээг хамт тайлагнаж хэвших
8. Бог малын мялзан өвчнөөс сэргийлэх вакцин 2016 онд БНХАУ-аас нэг тунг 314, 2017 онд ОХУ-аас 58, 2018 онд Энэтхэг улсаас 230 орчим төгрөгөөр худалдан авсан байна. Үнийг бараг 4 дахин өсгөж, өөр улсаас авах зайлшгүй шаардлага байсан эсэх, ТБОНӨХБАҮХАТХ-ийн 34.1.9-д заасан нөхцөл байдал бий болсон эсэх нь нотлогдохгүй байна.
9. ДМАЭМБ-аас зохион байгуулсан хурал, зөвлөгөөнд шаардсан буюу нэр заасан төлөөллийг оролцуулж байгаа эсэх мэдээллийг тайлагнаагүй.



Үр дүнгийн гэрээний хүрээнд:

1. 2019 оны төлөвлөлтөд хийсэн дүн шинжилгээ, тэдгээртэй холбоотой төлөвлөлтийн талаар тайлагнахаар тусгасан боловч 2018 оны хэрэгжилтийн талаар тайлагнасан,
2. 2018.06.01-нээс мөрдсөн Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуультай холбоотойгоор баталсан журам, заавар, тэдгээрийг мөрдөж эхэлсэн эсэх талаар тайлагнаагүй,
3. Зарим аймгуудаас бруцеллёзын оношлуур зэрэг нь цаг хугацаанаас хоцорсноос шинжилгээний ажил удааширч байгаа талаар мэдээлэл өгч байсан болно.
4. Вакцинжуулалтын төлөвлөлт, нийт төлийн болон хамруулах шаардлагатай охин төлийн хэдэн хувийг хамруулсан, вакцины болон үйлчилгээний хөлсний санхүүжилтийн төлөвлөлт, гүйцэтгэлийн талаар тайлагнах.
5. Бруцеллёзын стратеги, төлөвлөгөөнд тусгагдсан зорилт хангагдсан эсэх, бод, богийн төлөөр үр дүнг хэмжих, хангалтгүй үр дүнд ямар арга хэмжээ авч хэрэгжүүлсэн талаар тайлагнах. Мониторингийг бүх аймагт хэрэгжүүлэх шаардлагатай юу эсвэл хязгаарлагдмал хүрээнд хийсээр байх уу. Эндээс гарах үр дүн юу вэ гэдгийг тооцох
6. Өвчний заавар боловсруулах зэрэгт холбогдох байгууллагатай хамтран ажилласан уу. Санал авсан уу. Олон нийтэд хүргэсэн талаар-?,
7. Малчин сэтгүүл зэрэг байгууллага, агенттай гэрээ байгуулан сурталчилгаа хийсэн, өөрөө санхүүжүүлэн нийтэд хүргэсэн хуулийн болон бусад сурталчилгааны талаар тайлагнаагүй, Цаг үеийн мэдээллийг сурталчилгаа гэж ойлгосоор байх уу,
8. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн /30.20/ хэрэгжилтийг дэмжих журам батлагдаагүй
9. Гарын авлагаар хангагдаагүй. Орон нутгийн эмч мэргэжилтний хэдэн хувийг хангаж чадах талаар тайлагнаагүй. Зөвхөн нэг ном тархвар зүйн ойлголтыг бүрэн төлөвшүүлж чадах уу,
10. Тэмцэх арга хэмжээний төлөвлөлт өмнө нь хэрхэн хийгдэж байсан, одоо яаж боловсронгуй болсон талаар тайлагнах,
11. ЗГҮАХ-ийн тайланд шүлхийн 61, бог малын мялзангийн 5, хонины цэцгийн нэг тохиолдол бүртгэгдсэнээр тайлагнасан. Зөвхөн шүлхийн 25 тохиолдлыг ДМАЭМБ-д тайлагнасан нь мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн холбогдох заалтын хэрэгжилт хангаагүй.
12. Гарч болзошгүй өвчний талаар? /Гахайн африкийн мялзан, Үхрийн арьс товруутах, Крым Конг г.м/

13. Хэдэн дээж авсан, ямар арга зүйгээр шинжилсэн, ямар санхүүжилт гарсан гэх мэтээр бүрэн бичих. /Аргачлалд заасан нотлох баримт байхгүй/
14. Бог малын мялзан өвчнөөс сэргийлэх вакцинжуулалтын дараах мониторингийг 2018 оны вакцинжуулалтын дараа хийгээгүй.
15. Орон нутгаас вакцинжуулалтын арга хэмжээнд тавьсан хяналтын талаар тайлагнаагүй.
16. Шийдвэр гаргагчдыг мэргэжлийн удирдлагаар хангах ажил хийгдсэн үү. Дэгдэлтийг судлах, мэргэжлийн зөвлөл байгуулах, шийдвэр гаргагчдад шинжлэх ухаанч зөвлөмж өгөх гэх мэт
17. Мэдээллийн нээлттэй байдал хангалттай юу. Илүү нээлттэй ажиллах, мэдээлэл хийх ажиллагааг тогтмолжуулахаар хуулиар хүлээсэн үүрэг хэрхэн хангагдсан талаар тайлагнах шаардлагатай
18. Яг аль төрлийн хэдэн мэдүүлэг гаргасан бэ. Ялангуяа албан тушаалтан захиргааны акт гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө. Нотолгоогүй.

Аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газар

- Мал эмнэлгийн тайлангаас үзэхэд ариутгал халдваргүйтгэлд хамруулсан талбай, өвчний голомтын талбай болон шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд хамруулах малын тоо нэмэгдсэн зэрэг үр дүнгүүд байна. Гэвч шимэгчтэх өвчний оношилгоо, тархалтын судалгааг ихэнх аймагт хийхгүйгээр шууд эмчлэн сэргийлэх арга хэмжээг шууд хэрэгжүүлж байгаа байдал нийтлэг байна. Ариутгал, халдваргүйтгэлийн арга хэмжээг хэрэгжүүлэхдээ зөв бэлдмэлийг сонгон хэрэглэх, зааврын дагуу бэлтгэх, хэрэглэх зэрэг асуудалд онцгойлон анхаарах шаардлагатай. Илүү шинжлэх ухаанчаар судалгааны үндсэн дээр ул суурьтай хэрэгжүүлэх.
- Баянхонгор аймагт Байнгын ажиллагаатай хяналтын пост байгуулах ажлыг санаачлан Цагдаагийн газар, Хууль зүйн хэлтсээс барилга байгууламжийн зураг төсвийг хийж, барилгыг 100 сая төгрөгийн өртөгтэйгээр барьж ашиглалтад оруулсан байна. Цаашид тогтвортой үйл явуулах санхүү, хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх шаардлагатай. Шүлхий өвчний эрсдэлээс сэргийлэх зорилгоор хяналтын түр цэгийг сайтар зохион байгуулан ажиллуулсан байна. Гоц халдварт өвчингүй, тайван байдлаа хадгалж чадсанаар БНАЛАУ-д нийлүүлэх хонийг аймгаасаа нийлүүлэх боломж бүрдүүлсэн байна. “Эрүүл сүрэгтэн” шалгаруулж гэрчилгээжүүлсэн байна.
- Баянхонгор аймгийн мал эмнэлгийн газраас зохион байгуулан сумын малын эмч нараас шимэгчтэх өвчний сорилын тест авсан байна.
- Орон нутгийн вакцинжуулалтын арга хэмжээний үйлчилгээний хөлсний урьдчилгааг зарим аймгууд мал эмнэлгийн нэгжүүдэд олгосноор үр дүн сайжирч байгаа байдал байна. /Говь-Алтай, Хэнтий/
- Говь-Алтай аймаг Бруцеллёзын тандалтын сорьц цуглуулсан малыг ээмэгжүүлсэн нь мөшгих боломжийг бүрдүүлэх сайн талтай байна.
- Биокомбинат ТӨААТҮГ-аас орон нутгийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин таригдах ёстой графикт хугацаанд Дорнод аймагт нийлүүлэгдээгүй, Цусан халдварт, сахуу, галзуу зэрэг өвчнүүдээс урьдчилан сэргийлэх вакцин ирээгүй нийлүүлэлт удааширсан байна.

Аргачлалд заасан шалгуур үзүүлэлтийн хүрээнд бэлтгэсэн тайлантай холбоотойгоор.

1. Аргачлалын 6.1.1, 6.1.2-ийн шаардлагыг ихэнх тайлан хангахгүй байна.
2. Аймаг бүрийн шалгуур үзүүлэлтийн тоо зөрүүтэй байна.
3. Аргачлалд тусгасан шалгуур үзүүлэлтийн хүрээнд тайлагнаагүй байх. /Зарим нь ийм шалгуур байгаа эсэхээ мэдэхгүй байна
4. Хүрэх түвшинг тодорхойлоогүйгээс зарим гүйцэтгэлийг суурь түвшингээс үнэлэх шаардлагатай болсон
5. Суурь түвшингээс хүрэх түвшинг бууруулан тооцох зэргээр зохиомлоор биелэлтийг нэмэгдүүлж байна. /Өвчлөл, хорогдлыг нэмж төлөвлөсөн хэрнээ, угаалга, халдваргүйтгэлийг бууруулан тооцох зэрэг/
6. Бүртгэгдсэн шимэгчтэх өвчин байхгүй, гэтэл эмчлэн сэргийлэх арга хэмжээнд маш олон мал хамруулан тайлагнасан. Энэ бол урьдчилан сэргийлэх арга хэмжээ биш
7. Төлөвлөсөн шинжилгээний ажлын хэрэгжилтийг бүрэн тайлагнаагүй эсвэл үнэлгээнд орхиж тооцох
8. Хэд хэдэн эх үүсвэрийн жилийн эцсийн тоон мэдээллүүд зөрүүтэй. Урьдчилсан гүйцэтгэл үү, эцсийн гүйцэтгэлээр тайлагнасан уу гэх мэт нь тодорхойгүй.
9. Тайлан бичихдээ албан бичгийн стандарт фонт ашиглаагүйгээс танигдахгүй байх. Баян-Өлгий, Сүхбаатар
10. халдварт өвчнөөр хорогдсон малын тоонд зориудаар устгасан болон гоц халдварт, халдварт өвчний үед хорогдсон малын тоог нэгтгэн тооцоогүй
11. Адууны ям, үхрийн сүрьеэ өвчний тандалт шинжилгээнд 2012 оны масс тандалтаас гарсан зөвлөмжийг нэвтрүүлээгүй, шинжилгээний аргыг өөрчлөөгүй
12. Бруцеллёзын шинжилгээгээр өвчтэй буюу эерэг тохиолдол бүртгэгдээгүй аймаг байна. Үр дүнд итгэж болох уу.
13. Креолины уусмалаар халдваргүйтгэл хийх заавар бий юу.!
14. Аргачлалд заасан загварыг бөглөж, бичмэл тайланг хамт ирүүлж хэвших

- **Албан бичгийн стандарт фонт ашиглах.**

Ардбаагчид үндэслэлтэй өвчлөлийн тархаахгүй байх зорилгоор МЭА-ны нөөцөд байсан 2018 ийн 09 аймаг бүрийн 07-ийн А/453 тоот захирамжаар 2018 ийн 09 аймаг бүрийн 07-ийн 11 аймаг бүрийн 03-ийн 13 нийт 287 өвчтэй адууны сүрьеэ 59 аймаг бүрийн 710150 өвчтэй адууны сүрьеэ 698076 өвчтэй адууны сүрьеэ 98.2 өвчтэй адууны сүрьеэ 99,8 % -тай хийгдсэн.

- **Үр дүнг бүрэн тайлагнах.**

Бруцеллёзын шинжилгээнд 15,6 мянган хээлтүүлэгч, гоц халдварт шүлхий, мялзан өвчний тандалт шинжилгээг 1760 малд, ямын шинжилгээг 2000 адуу, сүрьеэгийн шинжилгээнд 1000 үхэр, АХЦБ өвчний шинжилгээг 1100 адуунд, лейкоз өвчний шинжилгээг 100 үхэрт, цусны паразит 200 дээжинд хийж, лабораторийн шинжилгээнд нийт 21,7 мянган мал хамрагдаж гүйцэтгэл 99,8 % -тай хийгдсэн.

- **Заавар баримтлах.**

Тухайн өвчний голомт, өвчлөлийг тархаахгүй байх зорилгоор МЭА-ны нөөцөд байсан гоц халдварт цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинаар Сүхбаатар сумын 158,0 том хонь, голомтын 8,6 мянган хургыг 2 удаа, хил залгаа Баруун-Урт сумын 140.0, Асгат сумын 4,0 том хонийг тус тус вакцинжуулж нийт 331,6 мянган тун вакцин зарцуулаад байна.

- **Оновчтой төлөвлөх.**

2018 онд 9 төрлийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин захиалан, нийт мал сүргийн 28,4 хувьд 1004,0 үйцэгтэй өвчтөнүүдийг 100% гаралт, судалгаа, өнгөрсөн 3 жилийн захиалгын дундаж, малын өсөлт зэргийг харгалзан сумдад хувиарлан олгосон.

- **Мэдээллийг нягтлан тайлагнах.**

Зөвлөгөөнд сумдын МЭҮТ-ийн 32 мэргэжилтэн, ХХМЭ-ийн ААН-ийн төлөөлөл 38, бусад төрөн болон төрийн бус байгууллагын 33, тус байгууллагын мэргэжилтэн, эмч 17, нийт 125 хүн хамрагдсан байна. Аймгийн Засаг дарга, түүний Тамгын газар, ХОХБТХ, ОБГ, МХГ, Статистикийн хэлтэс, УЦУОШГ-ын холбогдох мэргэжилтнүүд, ХХААХҮЯ-ны МЭҮТ-ын ахлах мэргэжилтэн н. Алтангэрэл нар мэдээлэл хийж оролцсон.

- **Урьдчилан сэргийлэх арга хэмжээ мөн үү.**

Паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар сумдын Засаг дарга нарын гэрээнд бүх бог мал, үхрийг угаалганд хамруулах, туулгалтанд бог малын 70%, бод малын 40%-ийг, боловсруулалтанд бог малын 50%, бод малын 25%-ийг тус тус хамруулахаар төлөвлөгөө өгч мал сүргийг угаалга, туулгалтанд хамруулах аймгийн Засаг даргын “Мал сүргийг шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах тухай” А/389 тоот захирамжаар боловсруулалтад 550.0 мянган мал хамруулахаас 1391.3 мянган малд хийж 252.9 % нь, туулгалтанд 650.0 мал хамрагдахаас 1215.1 мал хамрагдаж 186.9 %, угаалганд 2.5 сая мал хамрагдахаас 1969.6 мянган мал хамрагдаж 78.8 %, нийт аймгийн хэмжээнд паразитга өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд 3.7 сая мал хамрагдахаас 4.5 сая мал хамрагдаж 123.6 %-ийн биелэлттэй байна.

- **Төлөвлөлтөөс илүү хамруулсан бол эм биобэлдмэл хаанаас авсан, яагаад илүү хамруулсан тухай тайлбарлах**

Аймгийн Засаг даргын “Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ явуулах тухай” 2018 оны А/132 тоот захирамжаар халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 878.2 мянган толгой мал, амьтан хамрагдахаас технологит хугацаанд давхардсан тоогоор 919.0 мянган толгой мал, амьтан буюу 105%-тай хамруулсан

- **Мал эмнэлгийн тархвар зүйн нэр томъёог ашиглан зөв тайлагнах.**

Тандалтанд 33 хот айлын 8224 адуу хамрагдаж, өвчилсөн 289 /Өвчлөлийн хувь – 3.5%/, үхсэн 100 /Үхлийн хувь -34.6%/, зориуд нядалж зах зээлд борлуулсан -138/48,2%, эмчилж буй- 51/17,1% байна

Зөвлөмж.

1. Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга 55 дугаар зүйлийн 55.2 дахь заалт, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангахуйцаар гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтийг хангах,
2. Мал эмнэлгийн салбарын эрх зүйн баримт бичгийн шинэчлэлийг эрчимжүүлэх, мониторинг хийж сайжруулах,
3. Мал эмнэлгийн салбарт мөрдөх эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийг хангах,
4. Тоонд бус илүү үр дүнд суурилсан гүйцэтгэлийн шалгуур бүхий төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх,
5. Харьяа байгууллага, мал эмнэлгийн тасаг, нэгжийн үйл ажиллагааны ХШҮ аргачлалыг МЭЕГ дарга батлах,
6. Аргачлалд багтсан шалгуур үзүүлэлтийг жилийн эхэнд баталгаажуулж авч хэвших,


7. Мал эмнэлгийн тархвар зүйч бэлтгэх асуудлыг онцгойлон авч үзэх,
8. Мал эмнэлгийн мэдээ, мэдээний маягтыг шинэчлэх, олон улсын ангиллын дагуу мэдээллийг нэгтгэж хэвших,
9. Монгол Улсад ажиллах үедээ өгсөн олон улсын экспертийн болон дотоодын судлаачдын зөвлөмжийг мал эмнэлгийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх талаар санаачлагатай ажиллах,

4.4.3. Мал аж ахуйн салбар

Мал аж ахуйн салбарын үзүүлэлт гэсэн хүснэгтийн дүнгийн нэгтгэлийг аймаг тус бүрээр гаргав. Мал аж ахуйн салбарын үзүүлэлтэд Хээлтэгч хээлтүүлэгчийн тохирооны тоо, өвөлжилтийн бэлтгэл ажлын биелэлт, малын өсөлт, нэг малаас авах ашиг шим, мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн үзүүлэлт зэргийг багтаасан мэдээллийг ашигласан.

Мал аж ахуйн салбарын ерөнхий үнэлгээг арван дөрөвдүгээр графикт үзүүлэв.

График -14



Аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газрын мал аж ахуйн салбарын ажлын ерөнхий үнэлгээ дунджаар 89.0 хувьтай дүгнэгдсэн байна. ХХААХҮ-ийн сайдын 2017 оны А-159 дүгээр тушаалаар баталсан “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээг хийв.

Мал аж ахуйн салбарын дээрх үзүүлэлтүүдийг суурь түвшин, зорилтот түвшин, хүрсэн түвшин зэргийг харгалзан үнэлж байгаа одоогийн аргачлал нь бодит мэдээллийг бүрэн илэрхийлэх, үнэн зөв үнэлгээ хийхэд хангалтгүй байна.

Аймгийн ХХААГ-аас ирүүлсэн Мал аж ахуйн салбарын үнэлгээ харьцангуй өндөр буюу 86.3-100.0 хувь гэсэн үнэлгээтэй байсан. ХШҮДАГ-ын үнэлгээний явцад эдгээр тоон дүнгүүд 69.1-94.4 болж өөрчлөгдсөн байна. Үнэлгээний зөрүүг нэгдүгээр хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт -4

д/д	Аймгийн нэр	Аймгийн ХХААГ-ын үнэлгээ, хувиар	ХШҮДАГ-ын үнэлгээ, хувиар	Үнэлгээний зөрүү, хувиар
1	Архангай	86.3	87.9	+1.6
2	Баян-Өлгий	97.0	88.1	-8.9
3	Баянхонгор	100.0	89.6	-10.4
4	Булган	99.0	89.1	-9.9
5	Говь-Алтай	97.4	88.7	-8.7

6	Дорноговь	97.5	90.7	-6.8
7	Дорнод	96.0	90.5	-5.5
8	Дундговь	100.0	87.8	-12.2
9	Завхан	97.2	84.6	-12.6
10	Өвөрхангай	90.2	88.7	-1.5
11	Өмнөговь	95.4	88.4	-7.0
12	Сүхбаатар	97.9	87.8	-10.1
13	Сэлэнгэ	98.4	92.0	-6.4
14	Төв	99.6	88.5	-11.1
15	Увс	97.3	87.8	-9.5
16	Ховд	96.8	88.5	-8.3
17	Хөвсгөл	97.9	94.4	-3.5
18	Хэнтий	98.6	92.3	-6.3
19	Дархан-Уул	96.5	91.4	-5.1
20	Орхон	99.2	85.5	-13.7
21	Говьсүмбэр	100.0	86.7	-13.3

Аймгуудын ХХААГ-аас ирүүлсэн Мал аж ахуйн салбарын үзүүлэлтүүдийг нэгтгэн гаргасан хүснэгтээс үзэхэд дараах асуудлууд дээр анхаарал хандуулах шаардлагатай байсан. Үүнд:

1. Архангай амгийн Мал аж ахуйн салбарын хүрсэн түвшингийн дүн тайлангийн дүнтэй зөрсөн. Тайланд өссөн дүнгээр байхад шалгуур үзүүлэлт дээр багассан дүнтэй байна.

2. Баян-Өлгий аймгийн мал аж ахуйн салбарын ерөнхий үнэлгээг 101.0-115.2 хувиар, 4 үзүүлэлтийг 100-аас дээш үнэлгээтэй гэж дүгнэсэн байна.

3. Баянхонгор аймгийн Зорилтот түвшинг өмнөх оны суурь түвшнээс бууруулж тооцсоныг анхаарч, ажиллахыг,

4. Булган, Говь-Алтай, Дундговь, Дорноговь, Ховд, Дархан-Уул аймгуудын хувьд ХХААХҮ-ийн сайдын 2017 оны А/159 тушаалаар батлагдсан аргачлал, шалгуур үзүүлэлт хүснэгтийн дагуу тайлагналтыг сайжруулж хугацаандаа хүргүүлэхийг,

5. Завхан аймгийн ХХААГ малын тооны өсөлт гэсэн үзүүлэлт дэх малын тооны өсөлт буурсан дүнтэй байна. Тухайлбал 2018 оны зорилтот түвшин хонь 110.0 мянган толгой, ямаа 50,0 мянган толгой гэж тус тус тооцсон бол хүрсэн түвшин 0 мянга толгой буюу биелэлт 0 хувь болжээ. Энэ онд хонь, ямааны тоо толгойд өсөлт гараагүй гэсэн дүнтэй харагдаж байна

6. Харин Увс аймгийн хувьд ХХААХҮ-ийн сайдын 2017 оны А/159 тушаалаар батлагдсан аргачлал, шалгуур үзүүлэлтийн хүснэгтийн дагуу тайлагналтыг сайжруулж хугацаандаа хүргүүлэхийг,

7. Төв аймгийн ХХААГ нь сумдын түвшин дэх өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрэх түвшинг 92,4 хувь байхаар тооцсон, харин аймгийн хэмжээнд 87,5 хувь байхаар төлөвлөсөн, мөн дээрх үзүүлэлт нь өмнөх оны зорилтод түвшинтэй тооны хувьд адил байна. Иймд төлөвлөлтийг үндэслэлтэй хийж, хүрэх түвшинг тодорхой тогтоож, үр дүнг зөв тайлагнахыг,

9. Дархан-Уул аймгийн ХХААГ салбарын 2017 оны суурь түвшнээс 5 үзүүлэлтийн зорилтот түвшинг доогуур төлөвлөсөн байна.

10. Орхон аймгийн ХХААГ-нь сумдын түвшин дэх өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрэх түвшинг 100 хувь байхаар тооцсон, харин аймгийн хэмжээнд 89,0 хувь байхаар төлөвлөсөн,

мөн энэ оны зорилтод түвшингээ өнгөрсөн оны хүрсэн түвшингээс доогуур төлөвлөснийг анхаарч ажиллахыг

11. Говьсүмбэр аймгийн ХХААГ нь салбарын 2018 оны Зорилтод түвшингээ суурь түвшингээс доогуур төлөвлөсөн байгаа нь төлөвлөлтийн алдаа гэж үзэж байна. Аймгууд ХХААХҮ-ийн салбаруудын одоогийн суурь түвшинг судалгаа тооцооны үндсэн дээр бодитой тогтоож, суурь түвшнээс хамаарсан төлөвлөлтийг үндэслэлтэй хийж, хүрэх түвшинг тодорхой тогтоож, үр дүнг зөв тайлагнаж, тоонд биш чанарт анхаарч ажиллах шаардлагатай байна.

Дүгнэлт

1. Аймгуудын хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал аж ахуйн салбарын үзүүлэлтийн 2018 оны үйл ажиллагааны гүйцэтгэлд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний ерөнхий дундаж 89.0 хувьтай байгаа нь өмнөх онтой харьцуулахад 2.1 пунктээр буурсан дүнтэй байна.

2. Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын аргачлалд заасныг зөрчиж үр дүнгийн үзүүлэлтүүдийг дутуу бөглөх, хэмжих нэгжээс зөрүүтэй, тухайн оны үзүүлэлтэд тохируулж суурь түвшинг андуурч бичих, оны эхэнд өгсөн салбарын үзүүлэлтийг оны төгсгөлд өгөхдөө зарим тоон үзүүлэлтийг өөрчилж өгч байна.

3. ХХААГ-ын тайлан дахь салбарын үзүүлэлтүүдийн суурь түвшин, зорилтод түвшин, хүрсэн түвшиний тоон мэдээллийн баталгаатай байдлыг хангаж ажиллах асуудал тун хангалтгүй байна. Тухайлбал суурь түвшнээс доогуур төлөвлөх, зорилтод түвшинг тогтоохгүй байх, эсвэл хүрсэн түвшинг тайлагнахгүй зэрэг өмнөх оны алдаагаа давтан гаргах асуудал түгээмэл байна.

4. Аймгийн ХХААГ-аас ирүүлсэн Мал аж ахуйн салбарын үнэлгээ харьцангуй өндөр буюу 100 хувиас дээш өндөр үнэлсэн явдал гарч байгаад цаашид дүгнэлт хийх шаардлагатай, бидний одоо мөрдөж байгаа үнэлгээний хамгийн их тоон утга нь 100 хувь байна.

Зөвлөмж

1. ХХААХҮ-ийн сайдын 2017 оны А/159 тушаалаар батлагдсан “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх” аргачлалын шалгуур үзүүлэлтийн хүснэгтийн дагуу тайлагналтыг сайжруулахыг,


2. Аймаг, орон нутагт хэрэгжүүлсэн “Монгол мал” хөтөлбөр, “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримилах бодлого”-ын баримт бичгийн төлөвлөгөөний хэрэгжилт, бодит үр дүн, аймгийн хэмжээнд өрх, аж ахуйн нэгжид үзүүлсэн эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр үзүүлсэн дэмжлэг, бэлчээрийн усан хангамжийн талаар хийгдсэн аймаг, орон нутаг малчдын хөрөнгө оруулалтын нэгтгэлийг хүнс, газар тариалан, мал аж ахуй, хөнгөн үйлдвэрийн, хоршоо, үйлчилгээний, мал эмнэлгийн салбарын чиглэлээр гаргаж ажиллахыг ХХААХҮЯ-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга нарт зөвлөмж болгох,

4.4.4. Газар тариалангийн салбар

Газар тариалангийн салбарыг үнэлэхдээ “Газар тариалангийн үйлдвэрлэл”, “Газар тариалангийн салбарын бүтээмж”, “Усалгаатай тариалан”, “Хамгаалагдсан хөрс”, “Зоорины хангамж”, “Сургалт”, “Тариалангийн газрын ашиглалт, зохион байгуулалтын чиглэлээр хийсэн ажлын үнэлгээ”, “Тайлангийн чанар” гэсэн бүрэлдэхүүн хэсгүүдийг шалгуур болгон

хяналт-шинжилгээ, үнэлгээг хийлээ. Аймгуудын ХХААГ-ын 2018 оны газар тариалангийн салбарын ерөнхий дундаж **86.6** хувьтай үнэлэгдсэн байна.

График -15



2018 оны ургац хураалтын дүнгээр нийтдээ 444.7 мянган тонн үр тариа, үүнээс 428.6 мянган тонн улаанбуудай, 167.9 мянган тонн төмс, 99.2 мянган тонн хүнсний ногоо, 23.4 мянган тонн тосны ургамал, 134.3 мянган тонн тэжээлийн ургамал тус тус хураан авч буудай, төмснийхээ хэрэгцээг дотоодын ургацаас хангах боломжийг бүрдүүлсэн. Аймгууд жимс, жимсгэнэ, хүнсний ногооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор “Жимс, жимсгэнэ”, “Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөрийн дэд хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлж эхэлсэн.

“Газар тариалангийн үйлдвэрлэл”-ийн үзүүлэлтийн дундаж үнэлгээ 86.6 хувьтай дүгнэгдсэн ба хамгийн өндөр үнэлэгдсэн нь Сэлэнгэ аймаг 94.1 хувь, Орхон аймаг 94.0 хувь, Төв аймаг 93.7 хувьтай байгаа бол Архангай, Баян-Өлгий, Дундговь аймгууд хамгийн бага үнэлэгдсэн тул төлөвлөлт, шалгуур үзүүлэлтийг сайжруулах, зөвлөмжид тусгасан ажлуудыг үйл ажиллагаандаа тусгаж ажиллах шаардлагатай байна.

Газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, тайлагналтыг сайжруулах чиглэлд дараах ажлыг зөвлөмж болгож байна. Үүнд:

1. Аймгууд төлөвлөгөөгөө боловсруулахдаа Төрөөс Хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого, Тариалангийн салбарын дэд хөтөлбөрүүд болон тухайн аймгаас тариалангийн талаар хэрэгжүүлж буй бодлогуудад тусгасан салбарын зорилт арга хэмжээтэй уялдуулан төлөвлөлтийг сайжруулахыг,
2. ХХААХҮ-ийн сайдын 2017 оны А/159 тушаалаар батлагдсан “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх” аргачлалын шалгуур үзүүлэлтийн хүснэгтийн дагуу тайлагналтыг сайжруулахыг,
3. Аймгууд 2018 онд тариалангийн газрын ашиглалт, зохион байгуулалтын чиглэлээр хангалттай ажлууд хийж гүйцэтгээгүй, тариалангийн талбайг ойжуулах, ойн зурвас байгуулах ажил хийгдэхгүй байгааг анхаарч ажиллахыг,

Тариалангийн салбарын үйл ажиллагааны төлөвлөлт, тайлагналтыг сайжруулах чиглэлд аймгуудад дараах зөвлөмжийг өгч байна.

Архангай аймагт:

1. Төмс, хүнсний ногоо, усалгаатай талбайн хэмжээ өмнөх оноос буурсан байна. Цаашид хангамжийг нэмэгдүүлэх, өсөлтийг хадгалах чиглэлд анхаарахыг,
2. Зорилтот түвшнөө хэт өндөрөөр тооцсон нь үнэлгээ багаар гарахад нөлөөлж байгааг анхаарч төлөвлөлтийг сайжруулахыг,
3. Тариалангийн талбайн хөрсний үржил шимийг дээшлүүлэх, тариалангийн талбайг кадастрын зургаар баталгаажуулах, агрохимийн шинжилгээнд хамруулах чиглэлд үр дүнтэй ажлууд төлөвлөх, зохион байгуулахыг.

Баянхонгор аймагт:

1. Хэд хэдэн шалуур үзүүлэлт суурь түвшнөөс буурсан байна. Цаашид тариалангийн үйлдвэрлэлийн хангамжийг нэмэгдүүлэх, өсөлтийг хадгалах чиглэлд анхаарахыг,
2. Тариалангийн талбайн хөрсний үржил шимийг дээшлүүлэх, тариалангийн талбайг кадастрын зургаар баталгаажуулах, агрохимийн шинжилгээнд хамруулах чиглэлд үр дүнтэй ажлууд төлөвлөх, зохион байгуулахыг
3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шинээр болон сэргээн засварласан усалтын системийн ашиглалтыг сайжруулахыг,

Баян-Өлгий аймагт:

1. Үр тариа, төмс, хүлэмжийн ургац болон усалгаатай талбайн тариалалт, ургацын хэмжээ өмнөх оноос буурсан байна. Цаашид хангамжийг нэмэгдүүлэх, өсөлтийг хадгалах чиглэлд анхаарахыг,
2. Зоорины хангамж, хүлэмжийн тариалалтыг нэмэгдүүлэх, техникийн шинэчлэлийг эрчимжүүлэх чиглэлд анхаарахыг,
3. Аргачлалын дагуу тайлагналтыг сайжруулах, үр дүнг буруу тооцоолсон.

Булган аймагт:

1. Тариалангийн талбайн хөрсний үржил шимийг дээшлүүлэх, агрохимийн шинжилгээнд хамруулах, ойн зурвас байгуулах ажлууд өмнөх оноос ахиц гараагүй тул үр дүнтэй ажлууд төлөвлөх, зохион байгуулахыг,
2. Зарим шалгуур үзүүлэлтүүдийг тогтоохдоо зорилтот түвшнөө хэт өндөрөөр тооцсон нь үнэлгээ багаар гарахад нөлөөлж байгааг анхаарч төлөвлөлтийг сайжруулахыг,

Дархан-Уул аймагт:

1. Үр тариа, төмс, хүлэмжийн ургац болон усалгаатай талбайн хэмжээ өмнөх оноос буурсан байна. Цаашид хангамжийг нэмэгдүүлэх, өсөлтийг хадгалах чиглэлд анхаарахыг,
2. Тариалангийн талбайн хөрсний үржил шимийг дээшлүүлэх, тариалангийн талбайг кадастрын зургаар баталгаажуулах, агрохимийн шинжилгээнд хамруулах, ойн зурвас байгуулах чиглэлд үр дүнтэй ажлууд төлөвлөх, зохион байгуулахыг,

Дорнод аймагт:

1. Газар тариалангийн үйлдвэрлэлд ажиллагсдыг тогтвор суурьшилтай ажиллуулах чиглэлд анхаарахыг,
2. Тариалангийн талбайн хөрсний үржил шимийг дээшлүүлэх, тариалангийн талбайг кадастрын зургаар баталгаажуулах, агрохимийн шинжилгээнд хамруулах, ойн зурвас байгуулах чиглэлд үр дүнтэй ажлууд төлөвлөх, зохион байгуулахыг,

Дорноговь аймагт:

1. Усын хэмжээнд үйлдвэрлэлд газар тариалангийн бүтээгдэхүүний эзлэх хэмжээг төлөвлөх, үр дүнг тооцохыг,
2. Төмсний нэгжийн ургац өмнөх оноос буурсан байна. Цаашид хангамжийг нэмэгдүүлэх, өсөлтийг хадгалах чиглэлд анхаарахыг,
3. Аргачлалын дагуу тайлагналтыг сайжруулахыг,
4. 25 шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин зорилтот түвшинтэйгөө ижилхэн байна. Үр дүнгийн үзүүлэлтийн төлөвлөгөөг шалгуур үзүүлэлтээр гаргаж нэгдүгээр улиралд ХШҮДАГ-т ирүүлж хэвшихийг,
5. Жилийн турш газар тариалангийн үйлдвэрлэлд орон нутгийн төсвөөс 90.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулсан уу? Тайлагналтад анхааралтай хандахыг,
6. Тариалангийн талбайн хөрсний үржил шимийг дээшлүүлэх ойн зурвас байгуулах, агрохимийн шинжилгээнд хамруулах, тариалангийн талбайг кадастрын зургаар баталгаажуулах чиглэлд үр дүнтэй ажлууд төлөвлөх, зохион байгуулахыг,

Дундговь аймагт:

1. Төмс, хүнсний ногооны хангамж, ургацын хэмжээ зэрэг гол үр дүнгүүд өмнөх оноос буурсан байна. Цаашид хангамжийг нэмэгдүүлэх, өсөлтийг хадгалах чиглэлд анхаарахыг,
2. Усалгаатай тариалан, хүлэмжийн тариалалтыг нэмэгдүүлэх, техникийн шинэчлэлийг эрчимжүүлэх чиглэлд анхаарахыг,
3. Техникийн шинэчлэлийн хувь өмнөх онуудаас буурсан нь механик алдаа юу? Аргачлалын дагуу төлөвлөлт, тайлагналтыг сайжруулахыг,
4. Хүлэмжийн тариалалтыг нэмэгдүүлэх чиглэлд анхаарах, үр дүнтэй ажлууд зохион байгуулахыг,
5. Тариалангийн талбайн хөрсний үржил шимийг дээшлүүлэх, тариалангийн талбайд ойн зурвас байгуулах, тариалангийн талбайг агрохимийн шинжилгээнд хамруулах, кадастрын зургаар баталгаажуулах чиглэлд үр дүнтэй ажлууд төлөвлөх, зохион байгуулахыг,

Говь-Алтай аймагт:

1. Өмнөх жилийн зарим шалгуур үзүүлэлтийг шинэчлээгүй, тайлагналтын чанарыг сайжруулахыг,
2. Улсын хэмжээний үйлдвэрлэлд эзлэх хувь, хангамжийг тодорхойлохыг,
3. Үр тарианы нэгжийн ургацыг 47.5 цн/га гэж тайлагнасан, тайлангийн үнэн бодит байдлыг нягтлахыг,
4. Усалгаатай тариалан, хүлэмжийн тариалалтыг нэмэгдүүлэх чиглэлд анхаарах, гүйцэтгэлийг суурь түвшингөөс бууруулахгүй байх, өсөлтийг хадгалах чиглэлд анхаарахыг,

5. Зохион байгуулсан сургалтын тоо нэмэгдсэн хэдий ч сургалтад хамрагдагсдын тоо 4 дахин багассан байна. Дүгнэлт хийж ажиллахыг,
6. Тариалангийн талбайн хөрсний үржил шимийг дээшлүүлэх, тариалангийн талбайд ойн зурвас байгуулах чиглэлд үр дүнтэй ажлууд төлөвлөх, зохион байгуулахыг,

Говьсүмбэр аймагт:

1. Төмс, хүнсний ногооны хангамж, ургацын хэмжээ зэрэг гол үр дүнгүүд өмнөх оноос буурсан байна. Цаашид хангамжийг нэмэгдүүлэх, өсөлтийг хадгалах чиглэлд анхаарахыг,
2. Усалгаатай тариалан, хүлэмжийн тариалалтыг нэмэгдүүлэх, техникийн шинэчлэлийг эрчимжүүлэх чиглэлд анхаарахыг,
3. Техникийн шинэчлэлийн хувь өмнөх онуудаас буурсан нь механик алдаа юу? Аргачлалын дагуу төлөвлөлт, тайлагналтыг сайжруулахыг,
4. Зоорины хангамж, хүлэмжийн тариалалтыг нэмэгдүүлэх чиглэлд анхаарах, үр дүнтэй ажлууд зохион байгуулахыг,
5. Тариалангийн талбайн хөрсний үржил шимийг дээшлүүлэх, тариалангийн талбайд ойн зурвас байгуулах, тариалангийн талбайг агрохимийн шинжилгээнд хамруулах чиглэлд үр дүнтэй ажлууд төлөвлөх, зохион байгуулахыг,

Завхан аймагт:

1. Төмсний нэгжийн ургац өмнөх оноос буурсан байна. Цаашид хангамжийг нэмэгдүүлэх, өсөлтийг хадгалах чиглэлд анхаарахыг,
2. Зорилтот түвшингөө хүрсэн түвшингөөс бууруулж тооцсон төлөвлөлтийн алдааг сайжруулахыг,
3. Усалгаатай тариалан, Зоорины хангамж, хүлэмжийн тариалалтыг нэмэгдүүлэх, техникийн шинэчлэлийг эрчимжүүлэх чиглэлд анхаарахыг,
4. Тариалангийн талбайн хөрсний үржил шимийг дээшлүүлэх ойн зурвас байгуулах, агрохимийн шинжилгээнд хамруулах чиглэлд үр дүнтэй ажлууд төлөвлөх, зохион байгуулахыг,

Өвөрхангай аймагт:

1. Зуны хүлэмжээс хураан авсан ургацын хэмжээ өмнөх оноос буурсан байна. Цаашид хангамжийг нэмэгдүүлэх, өсөлтийг хадгалах чиглэлд анхаарахыг,
2. Тариалангийн талбайн хөрсний үржил шимийг дээшлүүлэх, тариалангийн талбайг кадастрын зургаар баталгаажуулах, агрохимийн шинжилгээнд хамруулах чиглэлд үр дүнтэй ажлууд төлөвлөх, зохион байгуулахыг,
3. Нийт 55 үзүүлэлт гаргахаас 35 үзүүлэлт буюу 62.5 хувь нь 100 хувиас дээш биелэлттэй гарсан. Биелэлт 100 хувиас дээш гарсан нь зорилтот түвшингөө буруу тооцоолсон төлөвлөлтийн алдаа гэдгийг анхаарахыг,

Өмнөговь аймагт:

1. Зоорины хангамж, шинээр хүлэмж байгуулах, хүлэмжийн тариалалтыг нэмэгдүүлэх, газар тариалангийн салбарт орон нутгийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, өмнөх жилийн өсөлтийг хадгалах, нэгжийн ургацыг бууруулахгүй байх чиглэлд анхаарахыг,

2. Тариалангийн талбайн хөрсний үржил шимийг дээшлүүлэх ойн зурвас байгуулах, агрохимийн шинжилгээнд хамруулах, тариалангийн талбайг кадастрын зургаар баталгаажуулах чиглэлд үр дүнтэй ажлууд төлөвлөх, зохион байгуулахыг,

Сүхбаатар аймагт:

1. Гурилын үйлдвэр байхгүй гэж тайлагнаад байна. Нийт үйлдвэрлэсэн үр тариагаар хичнээн хэмжээний гурил үйлдвэрлэх боломжтой, тухайн дүнгээр тайлагнахыг,
2. Аргачлалын дагуу тайлагналтыг сайжруулах, үзүүлэлт бүрийг үнэн зөв тайлагнахыг,
3. Зоорины хангамж, шинээр хүлэмж байгуулах, хүлэмжийн тариалалтыг нэмэгдүүлэх чиглэлд анхаарах, өмнөх жилийн өсөлтийг хадгалах чиглэлд анхаарахыг,
4. Тариалангийн талбайн хөрсний үржил шимийг дээшлүүлэх ойн зурвас байгуулах, агрохимийн шинжилгээнд хамруулах чиглэлд үр дүнтэй ажлууд төлөвлөх, зохион байгуулахыг,

Сэлэнгэ аймагт:

1. Газар тариалангийн салбарын 55 арга хэмжээний биелэлт гаргаснаас 50 арга хэмжээ буюу 90.9 хувь нь 100 хувиас дээш /1048 хувь хүртэл, дундаж үнэлгээ 157.9 хувь/ биелэлттэй байна. Биелэлт 100 хувиас дээш гарсан нь зорилтот түвшингөө буруу тооцоолсон төлөвлөлтийн алдаа гэдгийг анхаарахыг,
2. ХХААГ-ын зорилтот түвшинг 2018 нэгдүгээр улиралд ирүүлсэн төлөвлөгөөнөөс бууруулж дүгнэсэн тайлагналтын алдааг сайжруулахыг,

Төв аймагт:

1. Жимс жимсгэнийн тариалсан талбай өмнөх оноос буурсан байна. Жимс жимсгэнэ хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх, мөн цаашид хангамжийг нэмэгдүүлэх, өсөлтийг хадгалах чиглэлд анхаарч шаардлагатай байна.
2. Үр дүнг өндөр харагдуулахын тулд зарим зорилтот түвшинг багаар тооцсон нийтлэг дутагдлыг сайжруулахыг,
3. Тариалангийн талбайн хөрсний үржил шимийг дээшлүүлэх, ойн зурвас байгуулах, агрохимийн шинжилгээнд хамруулах чиглэлд үр дүнтэй ажлууд төлөвлөх, зохион байгуулахыг,

Увс аймагт:

1. Цаашид хангамжийг нэмэгдүүлэх, өсөлтийг хадгалах чиглэлд анхаарахыг,
2. Зоорь хүлэмжийг шинээр барих, техникийн шинэчлэл хийх чиглэлд үр дүнтэй ажил төлөвлөх, зохион байгуулахыг,
3. Тариалангийн талбайн хөрсний үржил шимийг дээшлүүлэх, тариалангийн талбайг кадастрын зургаар баталгаажуулах, агрохимийн шинжилгээнд хамруулах чиглэлд үр дүнтэй ажлууд төлөвлөх, зохион байгуулахыг,

Ховд аймагт:

1. Төмсний хангамж, усалгаатай талбайн хэмжээ өмнөх оноос буурсан байна. Цаашид хангамжийг нэмэгдүүлэх, өсөлтийг хадгалах чиглэлд анхаарахыг,

2. Төмс, хүнсний ногооны зоорины хангамж нэмэгдүүлэх, өвлийн хүлэмж байгуулах чиглэлд анхаарахыг,
3. Зохион байгуулсан сургалт, сургалтад хамрагдсан хүний тоо өмнөх он болон тухайн оны зорилтот түвшнөөс буурсан, эрчимжүүлэх, сургалтын үр дүнг дээшлүүлэх чиглэлд анхаарахыг,
4. Тариалангийн талбайн хөрсний үржил шимийг дээшлүүлэх, тариалангийн талбайд ойн зурвас байгуулах, агрохимийн шинжилгээнд хамруулах чиглэлд үр дүнтэй ажлууд төлөвлөх, зохион байгуулахыг,
5. Хүрсэн үр дүнг үнэн зөв тооцох. Аргачлалын дагуу тайлагналтыг сайжруулахыг,

Хөвсгөл аймагт:

1. Усын хэмжээнд үйлдвэрлэлд газар тариалангийн бүтээгдэхүүний эзлэх хэмжээг төлөвлөх, үр дүнг тооцох. Мөн сургалтад зарцуулсан хөрөнгийг мян төгрөгөөр гаргах ёстой, дээрх биелэлтээс 10 удаагийн сургалтад 400 төгрөг зарцуулсан уу? Аргачлалын дагуу тайлагналтыг сайжруулахыг,
2. Төмс, хүнсний ногоо, зоорины хангамж, хүлэмжийн тариалалтыг нэмэгдүүлэх чиглэлд анхаарахыг,
3. Бичмэл тайланд жимс, жимсгэнэ хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн хөрөнгө оруулалтаар 56.0 сая төгрөг зарцуулсан талаар тайлагнасан. Үр дүнгийн үнэлгээний хүснэгтэд тусгаагүй байна. Тайлангийн үнэн бодит байдлыг нягтлахыг,
4. Тариалангийн талбайн хөрсний үржил шимийг дээшлүүлэх, тариалангийн талбайг кадастрын зургаар баталгаажуулах, агрохимийн шинжилгээнд хамруулах чиглэлд үр дүнтэй ажлууд төлөвлөх, зохион байгуулахыг,
5. Салбарын үр дүнгийн үзүүлэлтийн үнэлгээний ерөнхий дүнг тооцохдоо хувиар илэрхийлсэн байна. Цаашид хувиар илэрхийлсэн тохиолдолд үнэлгээ өгөхгүйг анхаарахыг,
6. Бичмэл тайланд үр дүнгийн үзүүлэлтэд тусгасан ажлуудаар хязгаарлагдахгүйгээр ололт, амжилт, алдаа дутагдал, анхаарах зүйлс, шинэлэг ажил давуу талыг тайлагнаж хэвшихийг,

Хэнтий аймагт:

1. Үр тарианы нэгжийн ургац өмнөх оноос 9.9 цн/га-аар, төмс, хүнсний ногооны нэгжийн ургац 37.5-80.7 цн/га-аар нэмэгдсэн амжилттай байна. Гэтэл жимс, жимсгэнийн хангамж өмнөх оноос буурсан байна. Цаашид хангамжийг нэмэгдүүлэх, өсөлтийг хадгалах чиглэлд анхаарахыг,
2. Орон нутгийн төсвөөс газар тариалангийн үйлдвэрлэлд 1.7 сая төгрөг зарцуулсан хэмээн тайлагнасан, гэтэл сургалтад зориулан 13.0 сая төгрөг зарцуулсан гэж тайлагнасан байна. Тайлангийн үнэн бодит байдлыг анхаарахыг,
3. Тариалангийн талбайн хөрсний үржил шимийг дээшлүүлэх ойн зурвас байгуулах, агрохимийн шинжилгээнд хамруулах чиглэлд үр дүнтэй ажлууд төлөвлөх, зохион байгуулахыг,

Орхон аймагт:

1. Усалгаатай тариалан, хүлэмжийн тариалалтыг нэмэгдүүлэх, техникийн шинэчлэлийг эрчимжүүлэх, газар тариалангийн салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиглэлд анхаарахыг,
2. Тариалангийн талбайн хөрсний үржил шимийг дээшлүүлэх ойн зурвас байгуулах гэрээ байгуулах чиглэлд үр дүнтэй ажлууд төлөвлөх, зохион байгуулахыг,

4.4.5. Хөнгөн үйлдвэр, жижиг дунд үйлдвэр, хоршооны салбар

Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг үндэслэн, ХХААХҮ-ийн сайдын 2017 оны А-159 дүгээр тушаалаар батлагдсан “ХХААХҮ-ийн салбарын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээг дараах үзүүлэлтүүдээр дүгнэж гүйцэтгэв. Үүнд:

а. Аймгуудын Хөнгөн үйлдвэрийн салбарын ажлын үр дүнг Засгийн Газрын 2018 оны 36 дугаар тогтоолоор батлагдсан “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөрийн хавсралтад тусгагдсан орон нутагт 2018-2020 онд шинээр баригдаж, ашиглалтад орох үйлдвэрүүдийн ажлын явц, гүйцэтгэл, ХҮБХЗГ-ын ХХААГ-ын хөнгөний салбарын ажлыг дүгнэсэн үнэлгээ болон үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд,

б. Аймгуудын Жижиг, дунд үйлдвэрийн салбарын ажлын үр дүнг үнэлэхдээ аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, ХХААГ-ын жилийн ажлын төлөвлөгөөнд ЖДҮХоршооны чиглэлээр тусгагдсан арга хэмжээний хэрэгжилт, ЖДҮБХЗГ-ын үнэлгээ болон үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд,

в. ХХААГ-ын 2018 оны жилийн ажлын тайлан, хөнгөн, ЖДҮ, хоршооны салбарын асуудлыг хариуцсан мэргэжилтнээс мэдээлэл авч, холбогдох статистик мэдээ, мэдээллийг ашиглав.

МУЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан ХХААХҮ-ийн салбарын зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангах хүрээнд тус яам дараах үндэсний хөтөлбөрүүдийг боловсруулан батлуулсан нь хөнгөн үйлдвэрийн салбарыг хөгжүүлэхэд томоохон алхам болсон. Үүнд:

1. **ЗГ-ын 2018 оны 36 дугаар тогтоол.** Орон нутгийн онцлог, нөөцөд суурилан дэвшилтэт

техник, технологи нэвтрүүлж, нэмүү өртөг шингэсэн, олон улсын чанар, стандартын шаардлага хангасан, өрсөлдөх чадвартай зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, тогтвортой үйлдвэрлэлийг хөгжүүлж, ажлын байр, гадаад, дотоод худалдааны эргэлт, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх зорилгоор “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөр,

2. **ЗГ-ын 2018 оны 47 дугаар тогтоол.** Ноолуурын бүрэн боловсруулалтын түвшинг 60 хувьд

хүргэж, байгаль орчинд ээлтэй эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлж, ноолууран бүтээгдэхүүний олон улсад өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор “Ноолуур” хөтөлбөрийг тус тус батлуулсан.

Хүснэгт-5

№	Аймаг	Хөнгөний салбарын ХШҮ	ЖДҮ, хоршооны салбарын ХШҮ	Дундаж үнэлгээ
---	-------	-----------------------	----------------------------	----------------

1	Архангай	85.55	83.97	84.76
2	Баян-Өлгий	91.65	87.33	89.49
3	Баянхонгор	78.40	82.22	80.31
4	Булган	83.56	88.23	85.90
5	Говь-Алтай	86.46	84.27	85.37
6	Говьсүмбэр	75.08	74.12	74.60
7	Дархан-Уул	92.90	90.88	91.89
8	Дорноговь	84.15	79.70	81.93
9	Дорнод	83.08	80.90	81.99
10	Дундговь	83.18	78.79	80.99
11	Завхан	78.50	78.52	78.51
12	Орхон	78.93	82.91	80.92
13	Өвөрхангай	95.18	94.21	94.70
14	Өмнөговь	83.83	82.36	83.10
15	Сүхбаатар	86.40	84.97	85.69
16	Сэлэнгэ	69.75	88.52	79.14
17	Төв	90.33	83.12	86.73
18	Увс	81.50	81.30	81.40
19	Ховд	80.58	82.46	81.52
20	Хөвсгөл	82.10	81.63	81.87
21	Хэнтий	83.98	86.55	85.27
Дундаж		83.58	83.66	83.62

АЙМГУУДЫН ХХААГ-ЫН ХӨНГӨН, ЖДҮ, ХОРШООНЫ САЛБАРТ ГАРСАН ОЛОЛТ, ДУТАГДАЛ:

Хөнгөн үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх ЗГ-ын 2018 оны 36 дугаар тогтоолоор батлагдсан “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөрийн хавсралтад тусгагдсан үйлдвэрүүдийг шинээр барьж байгуулах эхний жилийн ажлын явц орон нутагт харилцан адилгүй байна.

Тухайн аймаг, орон нутаг өөрсдийн байгалийн баялаг, түүхий эд, эдийн засаг, хүний нөөцдөө тулгуурлан боловсруулж гаргасан саналын дагуу энэхүү хөтөлбөр батлагдсан.

Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

Төв аймаг 2018 оныг “Үйлдвэр дэмжих жил” болгон зарлаж, “ЖДҮ-27” аймгийн дэд хөтөлбөр, Архангай аймаг “Худалдаа, үйлдчилгээний салбарыг дэмжих жил”, “Өрх бүр үйлдвэрлэгч” дэд хөтөлбөр, Баянхонгор, Өмнөговь аймаг “ХАА-үйлдвэржилтийн жил”, Ховд аймаг “Үйлдвэрлэгч-Ховд” дэд хөтөлбөр, Дорнод аймаг “Орон нутгийн үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээг дэмжих жил”, Говь-Алтай аймаг “1 сум-1 үйлдвэр” дэд хөтөлбөрүүдийг шинээр боловсруулан батлуулж, бусад аймгууд өмнөх үйлдвэрлэлийн чиглэлээр батлагдсан дэд хөтөлбөрүүдээ үргэлжлүүлэн, “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан аймгийн Засаг даргаар батлуулан хэрэгжүүлж байна. Булган, Баян-Өлгий, Дорноговь, Завхан, Өмнөговь, Увс аймгууд хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан аймгийн Засаг даргаар батлуулахаар, мөн Дорноговь аймаг “Өрх бүр үйлдвэрлэгч- Иргэн бүр санаачлагч” дэд хөтөлбөр боловсруулан аймгийн ИТХ-д хүргүүлсэн байна. Говьсүмбэр аймаг төлөвлөгөө боловсруулаагүй байна.

Аймгууд өрхийн үйлдвэрлэл, ЖДҮ эрхлэгчдийг дэмжин, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг нь сурталчлан борлуулах, зах зээлд нийлүүлэх зорилгоор үзэсгэлэн худалдааг жил ирэх бүр өргөн хүрээтэй зохион байгуулснаар хил зэргэлдээх аймаг, улс, гадаад орнуудад бүтээгдэхүүнээ гаргах, сурталчлах чиглэлээр тодорхой ахиц гарсан байна. Хил зэргэлдээх улсуудад үзэсгэлэн худалдаагаар иргэд, ЖДҮ эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг оролцуулж борлуулан, гэрээ байгуулж ажилласан байна. Архангай аймаг сарлагийн хөөврийг бүрэн боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн Япон, Англи Франц улсад экспортод гаргаж байна. Баянхонгор, Өвөрхангай, Өмнөговь аймгууд намар тэмээний баяраар малчид, өрхийн үйлдвэрлэгчид, ЖДҮ эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг хилийн боомтоор /Гурван тэс/ гарган худалдаалж, борлуулах, гэрээ хийж дэмжиж байгаа нь жилээс жилд өргөжин малчид, үйлдвэрлэгчдийн талархлыг хүлээсэн томоохон арга хэмжээ болжээ. Энэхүү арга хэмжээг цаашид үргэлжлүүлэн тогтворжуулах шаардлагатай.

Аймгуудын ХХААГ-аас ЖДҮХС болон СХС-ийн зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хийсэн хяналт, шалгалтын ажлыг авч үзэхэд 2015 оноос хойш олгогдсон СХС-ийн зээлийн ашиглалт, эргэн төлөлт харьцангуй сайн, өмнөх онуудад олгогдсон зээлийн үлдэгдлийг төлүүлэх талаар хууль хяналтын байгууллагад хандсан, зохих ажиллагаа хийгдсэн байгаа нь харагдаж байна.

Архангай аймаг: Ихтамир, Эрдэнэбулган, Булган, Цэнхэр, сумдыг төвийн бүс, Цахир, Хангай, Тариат, Өндөр-Улаан, Чулуут сумдыг баруун бүс, Жаргалант, Цэцэрлэг, Эрдэнэмандал, Хайрхан сумдыг хойд бүс, Өлзийт, Өгийнуур, Хашаат, Хотонт, Төвшрүүлэх, Батцэнгэл сумдыг зүүн бүс болгон хувааж, тухайн бүсийн сумдын нөөц боломжид тулгуурласан Үйлдвэржилтийн бүсийг тогтоосон байна.

Харин Хөнгөн үйлдвэрийн үр дүнг тооцох шалгуур үзүүлэлтийн зорилтот түвшинг буруу тодорхойлсон, Борцны үйлдвэр баригдаагүй.

Баян-Өлгий аймаг: Тус аймаг үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин, зээлийн дэмжлэгт хамруулснаар хатгамал, сүлжмэл эдлэл, малын тэжээл, эсгийний үйлдвэр ашиглалтад орсон. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг ХХААГ-ын даргаар батлуулсан бөгөөд аймгийн Засаг даргаар батлуулаагүй байна.

Баянхонгор аймаг: 2018 онд Бууцагаан суманд хуучин барилгыг сэргээн засварласан, 2019 онд ашиглалтад оруулна. Витафит ХХК Эрдэнэцогт суманд сүү, цагаан идээ боловсруулах үйлдвэрийн барилгыг 90%- тай барьж, дуусгах шатандаа ажиллаж байна. Үйлдвэрийг хугацаанд нь ашиглалтад оруулах.

Говь-Алтай аймаг: Аймгийн үйлдвэржилтийн газрын зургийг вэб-д суурилсан газарзүйн мэдээллийн сан /программ/ хэлбэрээр боловсруулан гаргасан. Ингэснээр үүсгэсэн дата-г тогтмол шинэчлэн урт хугацаанд ашиглах, бодлого боловсруулагч, төрийн албан хаагч эрх бүхий албан тушаалтан төдийгүй энгийн иргэн, хөрөнгө оруулагчид, аж ахуй нэгж компаниуд нийтээр ашиглах, өөрийн хүссэн газраасаа үзэх болон хүссэн үр дүн, шинжилгээг харах давуу талтай болсон байна. Дэлгэр суманд хуурай сүүний үйлдвэр байгуулахаар судалгааны ажил хийн сумын орон нутгийн хөгжлийн сангаас 15 сая төгрөгөөр үйлдвэрийн байрыг барьсан, тоног төхөөрөмжөө суурилуулсан, эрчим хүчний асуудлаас шалтгаалж удаашралтай байна.

Сэлэнгэ аймаг: 2018 онд мод боловсруулах цогцолбор үйлдвэр, барилгын материалын үйлдвэрийг барьж ашиглалтад оруулах талаар тодорхой ажил хийгдээгүй байна.

Төв аймаг: 2018 онд 2 үйлдвэр ашиглалтад орохоос Төмс боловсруулах үйлдвэр- Цардуулын үйлдвэрийг БНПУ-ын ЗГ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр Жаргалант суманд байгуулахаар шийдвэрлэгдсэн. Үйлдвэр байгуулах газрын гэрчилгээг ХХААХҮЯамны харъяа ТЭДСангийн нэр дээр гаргасан. “Электрон хавтан”-ийн үйлдвэрийн ТЭЗҮ-г боловсруулан 2019 онд “Монгол экспорт” хөтөлбөрийн хүрээнд хөрөнгө оруулалтыг шийдвэрлэхээр

ажиллаж байна. Зуун мод суманд байгуулахаар үндсэн чиглэлд орсон. Газар нь дуудлага худалдаагаар орохоор төлөвлөгдсөн байна. Эдгээр үйлдвэрийн асуудлыг 2019 онд хэрэгжүүлэх.

Увс аймаг: Төлөвлөлтийг бодит судалгааг үндэслэн хийдэггүйн жишээ: Тус аймагт тоосгоны 3 үйлдвэр ажилладаг бөгөөд эдгээр үйлдвэр нь аймгийг тоосгоор бүрэн хангаад зогсохгүй баруун аймгуудад тоосгоо нийлүүлдэг. Гэтэл тус аймгаас санал оруулсны дагуу “Үйлдвэржилт 21:100” хөтөлбөрт /хоногт 1920 ш тоосго үйлдвэрлэх/ өндөр даралтаар тоосго үйлдвэрлэх үйлдвэрийг байгуулахаар тусгасныг аймгийн ХХААГ, аймгийн ХБТХэлтэс ч манайх энэ саналыг тусгаагүй, өмнөх дарга нарын үед хийгдсэн байна гэсэн асуудлыг тавьж байна. Уг асуудлыг холбогдох газруудад нь тавьж шийдвэрлэх шаардлагатай.

Ховд аймаг: 2018 онд Төмөр эдлэлийн үйлдвэр ашиглалтад ороогүй байна.

Аймгуудад байгуулагдах хуурай сүүний үйлдвэрүүдийн ихэнх нь байр нь баригдсан, тоног төхөөрөмж нь суурилагдсан боловч эрчим хүч, усны асуудлаас шалтгаалан ашиглалтад орж чадахгүй удааширч байна. Эрчим хүчний асуудлыг орон нутаг яаралтай шийдвэрлэж 2019 онд ашиглалтад оруулах шаардлагатай.

Салбарын нийтлэг зөрчил:

Аймгуудын ХХААГ-ын хөнгөн үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн яамны ХҮБХЗГ-ын холбогдох салбарын мэргэжилтэнүүдтэй ажлын уялдаа холбоо туйлын хангалтгүй байна. Аймгийн ХХААГ-ын болон сумын ХАА-н тасгийн мэргэжилтнийг сургалтанд хамруулах, хөнгөн үйлдвэрийн салбарын чиглэлээр гарсан хууль, эрх зүйн баримт бичгүүдийн талаар сургалт зохион байгуулах, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах шаардлагатай.

Аймгийн ХХААГ-ууд зорилтот түвшингээ тооцож чадахгүй байна, мэргэжилтнүүд дараа жилийнхээ зорилтот түвшнийг өмнөх онуудын бодит тооцоо, судалгааг үндэслэн тодорхойлох,

Мэргэжилтнүүдийг тогтвор суурьшилтай ажиллуулахгүйгээс шалтгаалж, салбарын мэдээ тайлан хугацаандаа ирэхгүй хоцрох, улмаар Засгийн Газарт оруулж шийдвэрлүүлэх асуудалд сөргөөр нөлөөлөх тул ХХААГ-ын удирдлагууд мэргэжлийн боловсон хүчнийг зөв сонгох, төрийн албаны чадахуйн зарчмын дагуу шаардлага хангасан ажилтныг тогтвор суурьшилтай ажиллуулах хэрэгтэй байна.


Салбарын ажлыг сайжруулах чиглэлд өгөх зөвлөмж:

АЙМГУУДЫН ХХААГ-Т:

1. Үр дүнг тооцох шалгуур үзүүлэлтийн зорилтот түвшинг бодит судалгааг үндэслэн зөв тооцох,
2. “Үйлдвэржилт 21:100” хөтөлбөрийн хавсралтад тусгагдсан тухайн аймаг, орон нутагт барьж байгуулах үйлдвэрүүдийн ТЭЗҮ болон холбогдох хөрөнгө оруулалтыг шийдвэрлэж, хөтөлбөрийн хэрэгжилт болон ЗГ-ын тогтоолыг хэрэгжүүлж ажиллах,
3. “Үйлдвэржилт 21:100” хөтөлбөрийн хэрэгжилтийг улирал бүр ХҮБХЗГ болон ХШҮДАГ-т ирүүлж байх,
4. Төрийн албаны хуулийг хэрэгжүүлж, Төрийн албаны чадахуйн зарчмыг баримтлан, мэргэжлийн боловсон хүчнийг сонгож, тогтвор суурьшилтай ажиллуулах,
5. Аймгуудын ХХААГ-ын хөнгөн, ЖДҮ, хоршооны асуудлыг хариуцсан мэргэжилтнүүд ХҮБХЗГ, ЖДҮХБХЗГ-ын холбогдох мэргэжилтнүүдтэй ажлын уялдаа холбоогоо сайжруулж, нэгдсэн арга зүйгээр ажиллах,

6. Салбар хариуцсан мэргэжилтнүүдийг холбогдох сургалтанд хамруулж, мэдлэг мэргэшлийг нь дээшлүүлж ажиллахыг зөвлөж байна.

График -16



НЭГДСЭН ДҮГНЭЛТ

1. Аймгуудын хүнс, хөдөө аж ахуйн газрын 2018 оны үйл ажиллагааны гүйцэтгэлд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний ерөнхий дундаж дүн **86.0** хувьтай байгаа нь өмнөх онтой харьцуулахад бодитой өсөлт гараагүй байна.

2. Аймгуудын ХХААГ-ын 2018 оны ажлын үр дүнгийн үнэлгээг 2 дугаар хүснэгтэд үзүүлсэн бөгөөд бүх аймаг 80 хувиас дээш үнэлгээтэй гарсан байна. Үнэлгээгээр Төв, Дархан-Уул, Орхон аймгууд хамгийн өндөр үнэлэгдсэн. Манай газар (А) болон (В) үнэлгээ авсан газруудыг 1-ээс 21 хүртэл эрэмбэлсэн. Энд 21 дүгээр байрт эрэмблэгдсэн ХХААГ нь (В) буюу “Сайн” гэсэн үнэлгээтэй байгааг тэмдэглэж байна.

3. **Салбарын бодлого, төлөвлөлтийг оновчтой** болгох зорилгоор одоогийн суурь түвшинг судалгаа тооцооны үндсэн дээр бодитой болгож, түүнээс хамаарсан төлөвлөлтийг үндэслэлтэй боловсруулж хүрэх түвшинг тодорхой тогтоож, үр дүнг зөв тайлагнаж, тоонд биш чанарт анхаарч ажиллах шаардлагатай байгаа нь ХШҮ-ний дүнгээс харагдаж байна.

4. Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал, 5.3.1.4 дэх заалт, “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу бичиж тайлагнах хэрэгтэй байна.

5. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлтээс харахад Хүнс, хөдөө аж ахуйн газруудын **үйл ажиллагааны** ажлын үр дүн, үр нөлөө тодорхойгүй, зөвхөн тайланг онцгойлсон нөхцөл байдал ажиглагдаж байна.

6. Аймгууд төлөвлөгөөгөө боловсруулахдаа Төрөөс Хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого, салбарын дэд хөтөлбөрүүд болон тухайн аймгаас баримталж буй бодлогын баримт бичигт тусгасан салбарын зорилт арга хэмжээтэй уялдуулан төлөвлөх шаардлагатай байна.

АЙМГУУДЫН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРУУДАД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

1. ХХААХҮ-ийн салбарт шинээр батлагдсан хөтөлбөрүүдийг аймаг, орон нутагтаа зохион байгуулах дэд хөтөлбөр боловсруулан, төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх, холбогдох журам, аргачлалын дагуу тайлагнаж хэвшихийг;

2. Аймгууд төлөвлөгөөгөө боловсруулахдаа Төрөөс Хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого, салбарын дэд хөтөлбөрүүд болон тухайн аймгаас баримталж буй бодлогын баримт бичигт тусгасан салбарын зорилт арга хэмжээтэй уялдуулан төлөвлөх, зарим бодлого, хөтөлбөрийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулахыг;

3. Тайлагналтыг сайжруулах үүднээс ХХААХҮ-ийн Сайдын 2017 оны А-159 дүгээр тушаал, “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу бичиж тайлагнах. Мөн түүнчлэн хэрэглэгчийн үнэлгээг ЗГХЭГ-ын даргын 2017 оны 302 дугаар тушаал, “Хэрэглэгчийн үнэлгээний ерөнхий удирдамж”-ийг мөрдлөг болгохыг;

4. Төсвийн хөрөнгө оруулалтын ажлын чанар, үр дүнг дээшлүүлж, төсөл хөтөлбөр хөрөнгө оруулалтаар хийгдэж буй хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт, зориулалтын дагуу ашиглаж буй байдал, данс бүртгэл, тайлан тэнцэлд тусгасан байдалд байнгын хяналт тавих, Шилэн дансны тухай хууль, холбогдох журмын хэрэгжилтийг сайжруулахыг;

5. Тариалан эрхлэлтийг дэмжих сан, Мал хамгаалах сан, Жижиг дунд үйлдвэрийн дэмжих сангаас иргэн, аж ахуйн нэгжид олгосон зээлийн ашиглалт, зориулалт, эргэн төлөлтийг сайжруулахыг тус тус зөвлөмж болгож байна.

6. Салбар бүрээр өгсөн зөвлөмжийг үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлж, хэрэгжилтийг хагас бүтэн жилээр гаргаж Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлнэ үү.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ГАЗАР